

## **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ 5 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

### **НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 3 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/134 дүгээр захирамжаар “Говьсүмбэр аймгийн 2020-2024 оны стратеги төлөвлөгөө”-г баталлаа.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газар, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас Менежмент ба ур чадварын хүрээлэн ТББ-тай хамтран “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2016, MNS ISO 18091:2020” стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээ. Цаашид Чанарын менежментийн тогтолцооны ISO стандартыг төрийн бүх шатны байгууллагуудад нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөж байна.

Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг сайжруулах, үйл ажиллагааны ололттой дутагдалтай тал, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын үйл ажиллагаанд удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор Баянтал, Сүмбэр, Шивээговь сумын ИТХ-ын ажлын алба, сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад 2021 оны 05 дугаар сарын 25, 27, 29-ний өдрүүдэд сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд төрийн 78 албан хаагч хамрагдсан байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас 2021 оны 5 дугаар 6-ны өдөр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, нийтийн хоол, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ эрхлэгчидтэй цахим уулзалт зохион байгууллаа.

Тус уулзалтад худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний 35, төрийн байгууллагын 10 төлөөлөл оролцож, аймаг, орон нутагт хэрэгжих хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, нийгмийн олон талт арга хэмжээг танилцуулан, санал солилцлоо.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/40, А/41 тоот захирамжаар 2021 оны аймгийн “Аварга малчин өрх”, “Алдарт уяач”-ийг шалгаруулсан бөгөөд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хойшилж, 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр шагналыг гардуулан өгсөн.

2021 оны 3 дугаар сарын 14-ний өдөр хүчтэй шороон шуурга шуурч, шуурганы улмаас аймгийн хэмжээнд 760 гаруй сая төгрөгийн хохирол учирсан. Гамшгийн хохирлыг бууруулах чиглэлээр орон нутгаас шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд аймгийн Засаг дарга шороон шуурганы улмаас аймаг орон нутагт үүссэн хохирол, нөхцөл байдалтай холбогдуулан Улсын онцгой комисст хүсэлт тавьсны дагуу 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 6 гэр олгож, нийт 12 иргэнд гэр олголоо. Мөн улсын Онцгой комиссын зүгээс аймгийн Онцгой байдлын газарт автомашин, аймгийн Онцгой комисст шаардлагатай ариутгалын бодис, тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслийг хүлээлгэн өгсөн.

5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын хариу арга хэмжээний шар түвшинд шилжин ажиллаж, сүүлийн 24 хоногт шинээр халдвар бүртгэгдээгүй. Нийт халдварын тоо 50, эдгэрсэн 49, эмчлэгдэж байгаа 1 иргэн байна. Аймгийн хэмжээнд 11001 хүн вакцинд хамрагдахаас 1 дүгээр тунд 10196 хүн хамрагдаж, хамрагдалт 92.7 хувь, 2 дугаар тунд 7627 хүн хамрагдаж, хамрагдалт 69.3 хувь, хамрагдах боломжгүй 840 иргэн байна. Гэрийн ажиглалтад 169 иргэн байгаад хяналт тавин ажиллаж байна.

Улсын төсвийн 2020-2021 оны хөрөнгө оруулалтаар 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгыг шинээр барин ашиглалтан хүлээн авлаа. Шинэ барилгын нээлтийн ажлыг 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, Шадар сайд С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нар хүрэлцэн ирж, аймгийн нэгдсэн эмнэлэгт ПСР шинжилгээний иж бүрэн лаборатори, мэс заслын тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

### **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

2021 оны 5 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 2 847 751 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2 888 990 мянган төгрөг төвлөрүүлж, 101 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 442 527 мянган төгрөг төвлөрүүлэхээс 442 630 мянган

төгрөгийг төвлөрүүлж 100 хувь, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 346 033 мянган төгрөг төвлөрүүлэхээс 346 150 мянган төгрөг төвлөрүүлж 100 хувь, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1 859 528.1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2 100 210 мянган төгрөг төвлөрүүлж, 112 хувийн гүйцэтгэлтэй байна.

2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар татвар төлөгч хуулийн этгээд нийт 641 болсон байна. Татвар төлөгчдийг хариуцлагын хэлбэрээр харуулбал: ХК-1, ХХК-330, БН-5, ЗБН-9, Хоршоо-24, ХЗХоршоо-1, ОНӨҮГ-6, Салбар-64, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ-201 байна.

**Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр:** Тохжилт сүмбэр ОНӨААТҮГ, 3 дугаар сургууль, аймгийн Орон нутгийн хөгжил сангийн 2021 оны 1-4 сарын баримтанд хяналт шалгалт хийж зөрчлийг тухай бүрт арилгуулсан.

Талын илч ОНӨААТҮГ-аар 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 21 714.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 1 301.8 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, орон нутгийн орлого болгуулахаар, 1 178.0 мянган төгрөгийг төлүүлж, тус байгууллагын дансанд төвлөрүүлэхээр, нийт 2 479.8 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоолоо.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар 27 515.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс 9 494.9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 18 020.6 мянган төгрөгийн зөвлөмж өгөв. Цаашид дээрх гаргасан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Аймгийн хэмжээнд нийт төсвийн болон орон нутгийн өмчит 81 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. 2021 оны 4 дүгээр сарын шилэн дансны хуулийн хэрэгжилт 95.6 хувь буюу өмнөх сараас 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

#### Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

№	Төрөл	2020.05.25		2021.05.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян.төг/
1	Өндөр настан	1796	3765028.1	1916	4455771.2
2	Хөгжлийн бэрхшээлтэй	354	624200.7	291	521703.2
3	Тэжээгчээ алдсан	137	189307.9	120	206140.9
4	Үйлдвэрлэлийн осол	27	76563.1	45	120460.1
<b>Нийт дүн</b>		<b>2314</b>	<b>4655099.88</b>	<b>2372</b>	<b>5304075.4</b>

#### Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2020.05.25		2021.05.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/
1	ХЧТА тэтгэмж	446	58723,3	336	47088.6
2	ЖБА тэтгэмж	154	253410,8	173	330175.6
3	Оршуулгын тэтгэмж	27	27000	31	31000
4	ҮОМШӨ-ХЧТА	2	3617,2	13	12019.5
5	Ажилгүйдлийн тэтгэмж	295	179119,3	80	154825.7
<b>Нийт дүн</b>		<b>924</b>	<b>521870,6</b>	<b>633</b>	<b>575109.4</b>

#### Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдал	2020.05.25	2021.05.25
Шинээр	98	119
Мөнгө тушаасан	416	442
Тушаасан мөнгөн дүн /мян төг/	31071.6	73048.8

## ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 918 заалт, 8453 хүний нэр, 981 байгууллагын нэр, 2889 газар зүйн нэр, 1078 хуудас баримт программд холбосон. Архивын баримтаас 9 иргэнд лавлагаа мэдээлэл олгосон.

### Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 36
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 108
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 48
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 4
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 3
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 5

### Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 9
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 16
- Гэрээний бүртгэл - 48
- Барьцааны гэрээний бүртгэл - 207
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 6

### Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 5
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 15

### Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 5
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 14
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 87

Нийт 616 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

**Цагдаагийн хэлтэс нь:** Тайлант сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 83 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 20, зөрчлийн 63 хэрэг байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эрсдлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах тухай” А/142 дугаар захирамжийн дагуу 2021 оны 5 дугаар сарын 08-22-ны өдрүүдэд Улаанбаатар хот болон халдварын голомттой бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах, үйл ажиллагааг нь хязгаарлаагүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан болон иргэдийг дархлаажуулалтанд хамруулах, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлээгүй, QR код байршуулаагүй, холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авч ажиллаж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах батлагдсан цагийн хуваарьт хяналт тавьж ажилласан.

Тайлангийн хугацаанд зөрчил гаргасан 818 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас торгож, согтуугаар зөрчил гаргасан 49 хүнийг эрүүлжүүлж, 16 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 17 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

"Цагдаа-бидний бахархал" сэдэвт хүүхдийн гар зургийн уралдааныг зохион байгуулсан.

**Шүүхийн шинжилгээний алба нь:** Хэргийн газрын үзлэгт 8 удаа оролцсоноос хүний амь эрсэдсэн хэргийн газрын үзлэгт 1, зам тээврийн ослын 1, бусад хэргийн газрын үзлэгт 6 удаа оролцож, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 58 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь:** Ангийн үйлдвэрлэлд түшиглэн хөдөлмөрийн дадал олгох сургалтанд шаардлагатай хоригдлуудыг сурган гөлөм оёход 2 хүмүүжигч, оёдол оёх сургалтад 1 хүмүүжигч, мужааны сургалтад 1 хүмүүжигч, даалин оёх сургалтад 2 хүмүүжигч хамрагдаж байна.

Тайлант сард төлбөрийн 174 гүйцэтгэх баримт бичгийн 2667615.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 43 гүйцэтгэх баримт бичгийн 363456.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, 30.2 хувийн биелэлттэй байна.

**Онцгой байдлын газар нь:** Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг “Багц мессеж” үйлчилгээ ашиглан 683 малчин өрхөд хүргэн ажилласан.

Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газар, Онцгой байдлын газрын дарга нарын баталсан “Эм ханган нийлүүлэх төв”, “Хүүхэд хамгааллын байгууллага”, “Уул уурхай баяжуулах үйлдвэр”-ийн барилга байгууламжид төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 18-ны өдрүүдэд Сүмбэр, Шивээговь сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 18 иргэн, аж ахуй нэгжид зохион байгуулж, давхардсан тоогоор гал түймэр гарч болзошгүй 76 зөрчил илрүүлж, газар дээр нь 18 зөрчлийг арилгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 8, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх 17 албан шаардлага бичиж, холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Мөн “Шивээ-Овоо” ХК нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ахуйн галын аюулгүй байдлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг сахин биелүүлээгүй, галын аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүй тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар торгох арга хэмжээ авсан.

5 дугаар сарын 19-ний өдөр Шивээговь сумын Онцгой комиссын гишүүдтэй хамтран Коронавируст халдвар тархах эрсдэлийн үнэлгээг сумын хэмжээнд хийсэн.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа 9 газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм мөрдөлтөд шалгалт хийж, халдвар хамгааллын дэглэмийн шаардлага хангаагүй 1 газарт Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 500 000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн.

Аж ахуйн нэгж, байгууллагуудад халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байх үүрэг чиглэл өгсний дагуу хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн 6 газрын 595м<sup>2</sup>, хүнсний бус үйл ажиллагаа эрхлэгч 4 газрын 545м<sup>2</sup> талбай болон 4 байгууллагын 2255м<sup>2</sup> талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг Сүмбэр гурван бат ХХК-аар гүйцэтгүүлсэн.

Аймгийн хэмжээнд дархлаажуулалтын 6 цэгийн үйл ажиллагаанд эрүүл ахуй халдвар хамгаалал, эмчилгээний чанар, эм био бэлдмэлийн хяналтаар дэмжлэгт хяналт хийж, хадгалалтын дэглэм алдагдсан, тундаа хүрээгүй, тариураас шалтгаалсан 9 вакцины хорогдол, зүү суларч унасан, цуурсан 12 тариурын хорогдол зэрэг зөрчлүүд илэрч устгалд оруулав.

Мөн Мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид аймгийн төвийн вакцинжуулалтын цэгүүдэд батлагдсан хуваарийн дагуу вакцины хадгалалтын горим, иргэдийн зай барилт, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавин ажиллаж байна.

Манай аймгийн хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд ЕБС-ын 12-р ангийг нийт 217 суралцагч төгсөж байгаа бөгөөд 4 сургуулийн 23 анги танхимд 52 багш, 206 суралцагчид элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр танхимын хэлбэрээр давтлагад хамрагдаж байгаатай холбогдуулан хяналтын хийхэд цэвэрлэгээ ариутгал, халдваргүйтгэлтэй холбоотой 14 зөрчил илэрч, 11 зөрчлийг газар дээр нь арилгуулан, 3 зөрчлийг арилгуулахаар үүрэг чиглэл өгсөн.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын хуваарийн дагуу болон улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу 15 удаагийн шалгалтыг хийж, улсын байцаагчийн албан шаардлага 2, дүгнэлт 2, хяналт шалгалтын удирдамж, зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөр 9-ийг боловсруулж хяналт шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэв.

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 48, арчдасын 35, хөрсний 3, агаарын 12, ур чадварын 3, нийт 101 сорьцонд 376 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэсэн.

### **НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд лаборатори 5 дугаар сургуультай хамтран Ерөнхий боловсролын сургуулиуд болон цэцэрлэгүүдэд “Еко сургууль болон цэцэрлэг”-ийн хөтөлбөр танилцуулах онлайн сургалтын зохион байгууллага. Сургалтанд сургууль, цэцэрлэгийн нийт 50 багш, удирдлагууд хамрагдлаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд 12 дугаар ангийн “Сорилго- 2” шалгалтыг үнэлгээний шинжээч нартай хамтран зохион байгуулсан. Тус шалгалтад 206 сургч хамрагдлаа.

Боловсролыг дэмжих арга хэмжээний хүрээнд сургууль, цэцэрлэгийн танхимын бус сургалтын явцад гарсан агуулгын хоцрогдол арилгах зорилгоор 10 шинжээч зөвлөх багш ажиллаж, 5 сургууль, 6 цэцэрлэгт зөвлөн тусалсан.

Монгол Улсын Гавьяат багш Ш.Түмэн-Өлзийн нэрэмжит 18 дахь удаагийн Монгол бичгийн цахим олимпиад, уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаанд 120 багш, сурагч оролцсон.

Бага насны хүүхдийн ахуйн осол гэмтлээс хамгаалах сэргийлэх агуулгаар 5 төрлийн шторкыг хийж, цахим сайтуудад байршуулсан.

“Өсвөр насны хүүхдүүдэд нөхөн үржихүйн боловсрол олгох” арга зүйн сургалтыг аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран, ерөнхий боловсролын 5 сургуулийн Эрүүл мэндийн хичээлийн 8 багшийг хамруулан зохион байгууллаа. Сургалтанд хамрагдсан багш нар өөрийн сургуулийн өсвөр насны 9-12 дугаар ангийн 880 хүүхдэд мэдлэг, ойлголт өгч ажилласан.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан хүүхэд, залуусыг хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх, хорио цээрийн үед нийгмийн стресс бухимдлыг бууруулах, гэрийн нөхцөлд хүүхдийн хөгжлийг дэмжих, боловсрол мэдлэгийг эцэг эх болон багш нар хамтран хөгжүүлэхэд нөлөөлөх зорилгоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Дэлхийн Зөн ОУБ-ын Бор-Өндөр 1 ОНХөтөлбөртэй хамтран Багш-хүүхэд-гэр бүл системээр “Гэрээсээ цахимаар суралцъя, хөгжье” цогц сургалтыг 2021 оны 5 дугаар сарын 3-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулийн 5-12 дугаар ангийн 779 сурагч, 201 эцэг эх, 47 багш хамрагдсан.

Өсвөр насны хүүхдүүд, ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгохтой холбоотой зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор 2021 оны 04 сарын 25-ны өдрөөс 05 сарын 25-ны өдрүүдийн хооронд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 11-12 дугаар ангийн сурагчдад “Мэргэжил сонголт миний ирээдүй” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулсан. Сургалтад 121 сурагч цахимаар хамрагдсан.

Мөн Говьсүмбэр аймгийн Дуу бүжгийн Боржигин чуулгатай хамтран 2021 оны 5 дугаар сарын 4-25-ны өдрийн хооронд хүмүүсийн ажил мэргэжлийн онцлог болон урлагийн авьяасыг олон нийтэд түгээх зорилготой “Мэргэжил бүхэн сайхан” цуврал цахим контент бэлтгэн, тайлант хугацаанд нийт 13 цуврал контент бэлтгэн, давхардсан тоогоор нийт 52500 хүний хандалт авсан байна.

Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих 2021 оны арга хэмжээний хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас санаачлан залуучуудын хөгжилд зориулан “Орон нутгийн хөгжил-30” залуучуудын чөлөөт ярилцлага подкаст, нэвтрүүлгийг цуврал болгон бэлтгэн хүргэж байна.

**Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр:** Гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээний хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Хүүхдийн дуу хоолойг сонсох өдөр”-ийн цахим уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад аймгийн Засаг дарга, болон сумдын Засаг дарга нар, хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгч байгууллагуудын удирдлага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагууд, сурагчдын нийт 40 төлөөлөл хамрагдлаа.

**Соёл, урлагийн чиглэлээр:** Дэлхийн бүжигчдийн баярын өдрийг тохиолдуулан цахим мэндчилгээг 3700 үзэгчдийг хамруулж, 5994 хүнд хүргэж, Хөгжим ангийн уран бүтээлчид “Ковидгүй зун-2021” аяны хүрээнд цахим мэндчилгээг нийт ард иргэдэд уриалга болгон хүргэж, 1700 гаруй хандалтыг авч, 3294 хүнд хүрч соёл, урлагийн үйлчилгээг хүргэж ажилласан байна.

“Үндэсний бичиг үсгийн баяр-2021” арга хэмжээний хүрээнд Монгол бичгээ сурах уриаг дэвшүүлж, үндэсний бичгээ сурах уриалга, танилцуулга, цахим мэндчилгээний контентыг иргэдэд түгээж, Монголын Үндэсний Радиоогоор тус байгууллагын Монгол бичгийн сургалтын тухай нэвтрүүлгийг түгээсэн.

Говьсүмбэр аймгаас төрөн гарсан гавьяатуудыг цуврал болгон цахимаар танилцуулан олон нийтэд сурталчлан таниулах, алдаршуулах ажлыг зохион байгуулж байна.

2021 оны 05 дугаар сарын 14-16-ны хооронд Боржигин өв музейн албан хаагчид Сүмбэр сумын 5,6-р багийн нутаг дэвсгэр дэх түүх Чойр уул, уулзварын гол, өлзийтийн гол, Хөшөөтийн хар өндөр, Сансар уул, Малх уул, Сүмбэр уул, Шархадны өвөлжөөний булш хиргисүүр, Өвөр дэлгэр, Зараа булан хэрлэн гол зэрэг 34 газруудын түүх соёлын үл хөдлөх 261 дурсгалуудыг эргэж хяналт шалгалт, тэмдэгжүүлэлтийг сэргээх, бүртгэлд нэмэлт баяжилт

хийх, хууль бус малтлагуудаас урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж гүйцэтгэж, Сүмбэр сумын 4 иргэнтэй 14 газрын 72 газрыг эзэнжүүлж хамгаалалтын гэрээ байгууллаа.

**Спортын чиглэлээр:** “Эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд Биеийн тамир, спортын газраас өглөө бүр гүйлт, дасгал хөдөлгөөн, волейбол, хөл бөмбөг, иог, аэробик, хийн дасгал, хөгжилтэй буухиа, гимнастик, спортын бүжиг зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 13 байгууллагын 288 албан хаагч, иргэд хамрагдаад байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2020 оны 05 сарын 20-ны байдлаар	2021 оны 05 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	187	157
Гэрийн төрөлт	0	2
Амьд төрсөн хүүхэд	189	159
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	30	28
Эмнэлгийн нас баралт	2	7
Хоног болоогүй нас баралт	0	3
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	2068	1107
Амбулаторийн үзлэг	41386	38683
Халдварт өвчин	53	55

Олон улсын сувилагч нарын өдрийг тохиолдуулан Эрүүл мэндийн газраас санаачлан Эрүүл мэндийн яам, аймгийн Засаг даргын Тамгын газрын хамтарсан цахим уулзалт зохион байгуулан мэндчилгээ дэвшүүлж, шилдэг сувилагчдыг шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулав.

Улсын Онцгой комиссын Шуурхай штабаас хяналт шалгалтын ажлын хэсэг 2021 оны 5 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд орон нутагт ажиллаж, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагаа болон эрүүл мэндийн байгууллагуудын Ковид-19 халдварын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний нөхцөл байдалтай танилцаж, дэмжлэгт хяналт хийлээ.

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд 13 иргэнийг хамруулсан бөгөөд өссөн дүнгээр 125 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөх үйлчилгээг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Ажил олгогч аж ахуй нэгж байгууллагаас 74 сул, чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч, бүртгэлтэй ажил хайгч иргэдэд утсаар болон цахим мэдээллийн хэрэгслээр хүргэж, 20 иргэнийг байнгын ажлын байранд, түр ажлын байранд 3 иргэнийг зуучилж, ажилтай орлоготой болгосон.

“Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлэе” уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян - 2021 арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын хүрээнд аяны талаарх мэдээллийг цахимаар болон албан байгууллагаар дамжуулан 3 удаагийн давтамжтайгаар иргэдэд хүргэж, 653 иргэн хандалт хийсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан 5 удаагийн давтамжтайгаар хүргэсэн. Аяны хүрээнд мөн 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 318 иргэнийг хамруулаад байна.

2021 онд хэрэгжих Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үндсэн 5 хөтөлбөр 19 арга хэмжээ хэрэгжих бөгөөд хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээний төслийн зарыг [www.govisumber.hudulmur-halamj.gov.mn](http://www.govisumber.hudulmur-halamj.gov.mn), аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар фэйсбүүк хуудас, иргэдийн ашигладаг зарын группээр ажлын байрны мэдээлэл болон хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг 1900 иргэнд хүргэсэн.

2021 оны 5 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас дараах хөнгөлөлт, үйлчилгээнүүдийг үзүүллээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр 253 хүнд 178.3 сая төгрөг

- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 252 хүнд 113.1 сая төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 222 хүнд 82.6 сая төгрөг
- Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 497 хүнд 8.1 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 52 хүнд 6.1 сая төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа 671 хүнд 31.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Шилдэг тохижилт бүтээн байгуулалт”, “Өрхийн тариалан эрхлэлтийг дэмжье” аяныг зарлаж, нээлтийн үйл ажиллагааг 2021 оны 5 дугаар сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Нээлтийн үеэр 14 сая төгрөгийн шагналын сан бүхий “Шилдэг тохижилт, бүтээн байгуулалт бий болгосон иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах уралдааныг зарлалаа.

Мөн өрхийн тариалан эрхлэх сонирхолтой 66 иргэнд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 3.0 сая төгрөгийн үнэ бүхий 2 тн төмсний үр, 100 кг төл сонгино, 300 ширхэг огурцы, улаан лоолийн үрийг үнэ төлбөргүй олгосон. Мөн Засгийн газрын шийдвэрээр 2021 оны хаврын тариалалтад зориулан хөнгөлөлттэй олгож буй 10 төрөл /бууцай, урт сонгино, хүрэн манжин, амтат чинжүү, шар лууван, сармис, хүлэмжний лооль, хэмх, тарвас зэрэг/-ийн үрийг давхардсан тоогоор 94 иргэнд хөнгөлөлттэй үнээр олголоо.

2020-2021 оны өвөл аймгийн нийт бэлчээр цасан бүрхүүлтэй, бэлчээрийн тэжээлийн хүртээмж муу, хаварт хүчтэй цасан болон шороон шуурга 3 удаа болж, 8.3 мян.мал хорогдсон. Өвөлд отрын мал ихтэй, хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан 1 дүгээр сараас 4 дүгээр сарын сүүлийн 10 хоног хүртэлх хугацаанд улсын нөөц болон аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөөс мөн олон улсын байгууллагын санхүүжилт, тусламжаар нийт 20616 боодол өвс, 7260 уут тэжээл, 300 хүнсний багцыг давхардсан тоогоор 3078 малчин, мал бүхий өрхөд хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй олгосон.

5 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар Малх отрын бүсэд 5 аймгийн /Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Төв, Говьсүмбэр/ 112 өрхийн 96.0 мян.тол мал, отрын бүсээс гадна 126 өрхийн 82.0 мян.тол мал отроор хаваржиж, зусаж байна. Дорноговь аймагт өвөлжиж, хаваржсан Дундговь, Өвөрхангай аймгийн оторчид ихээр орж ирсний улмаас бэлчээрийн даац, багтаамж 3-5 дахин хэтэрсэн, малын сэг зэм их нэмэгдэж байна. Гадны аймаг, сумаас отроор байгаа өрхүүдийг бэлчээр чөлөөлөх, отрын гарцаар гарах талаар албан мэдэгдэл өгч, Сүмбэр сум, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэстэй хамтран ажиллав. Малын хорогдол өмнөх оны мөн үеэс 19 дахин нэмэгдсэн байна.

2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 166173 эх мал төллөхөөс 118620 эх мал төллөж, 118944 төл гарсан. Үүнээс 108579 төл бойжиж байна. Төллөлт 71.4 хувьтай, төл бойжилт 91.3 хувьтай байна. Мөн төлийн хорогдол 10365, том малын хорогдол 18965 буюу оны эхний нийт малын 4.2 хувийг эзэлж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны 3 дугаар сарны 16-ны өдрийн “Мал бүртгэлжүүлэлтийн аян зохион байгуулах тухай” А/72 дугаар тушаалын хэрэгжилтийн ханган малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх аймгийн нэгдсэн төлөвлөгөө гаргаж, бүртгэлжүүлэлтийн аяныг эхлүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан “Ажлын байрыг дэмжих 2 их наяд төгрөгийн зээл” олгох ажлын хүрээнд орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд ажлын байраа хадгалах, бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийг бүрдүүлэх зээлийн нөхцөл, батлан даалтын үйл ажиллагааны талаар видео контент бэлтгэн байгууллагын цахим хуудсаар болон орон нутгийн телевизээр иргэдэд хүргэсэн.

Хөдөө аж ахуйн 15 хоршооны төлөөллийг хамруулан цахим сургалтыг зохион байгуулж, сургалтын хэрэгцээг тодорхойлон, “Мал төхөөрөх, арьс шир эсгэлтгүй өвчих технологи” цахим сургалт зохион байгуулсан. Тус сургалтад нийт 28 иргэн хамрагдан мэдлэг чадвар олж авсан.

Аймгийн дүнгээр төмс 6.5 га-д, хүнсний ногоог 2.1 га-д тариалаад байна. Хүнсний ногооны дотоод үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг сайжруулах, экологийн боловсролд нэмэр болгох зорилгоор “Өрхийн тариалалтыг дэмжье” аяныг зохион байгуулж байна. Хаврын тариалалттай холбоотой үрийн захиалгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж, 10 төрлийн таримлын үрийг хөнгөлөлттэй нөхцлөөр хуваарийн дагуу авах, “Өрхийн тариалалтыг дэмжье” аяны хүрээнд 4 төрлийн таримлын 2.9 сая төгрөгийн үрийн дэмжлэг үзүүлээд байна.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 5 дугаар сарын үнийн мэдээ**

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 20-1000 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /ястай, цул/ 500 төгрөгөөр, Хонины мах /ястай, цул/ 500-1000 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ, төг	Доод үнэ, төг	Өссөн буурсан /3-р сараас/	
1	Үхрийн мах	Ястай	11000	10000	+500
		Цул	13000	12000	-
2	Хонины мах	Ястай	9000	8500	+500
		Цул	12000	11000	+1000
3	Адууны мах	Ястай	6500	6000	-
		Цул	8500	8000	-
4	Ямааны мах	Ястай	7000	6500	-
		Цул	9500	9000	-
5	Лууван	Монгол	1800	1000	-
		Хятад			
6	төмс	Монгол	1300	850	-
		Хятад			
7	Байцаа	Монгол	2000	1800	-
		Хятад			-
8	чинжүү	Монгол	8500	7000	-
		Хятад	7500	4500	
9	Манжин	Монгол	2000	1500	
		Хятад			-
10	Сонгино бөөрөнхий	Монгол	4000	1800	-
		Хятад	-	1400	-
11	Помидор	Монгол	7500	5500	-
12	Өргөст хэмх	Монгол	7500	6500	-
13	Элсэн чихэр	Монгол	3000	2300	-
14	Будаа	Цагаан задгай кг	3000	2400	-
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
15	Сүү	Задгай	3450	3000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
16	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
17	Талх	Чойр талх	1200	1150	-
18	Өндөг	Монгол	550	450	-
19	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1210	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-



		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
20	Ургамлын тос	Олейна	5500	5200	-
		Алтан	4500	4500	-

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах зэрэг байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй зөв дадал хэвшүүлэх, хог хаягдлыг бууруулах, ногоон соёлыг бий болгох, хандлагаа өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, иргэн, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг идэвхжүүлэх, хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор "Хотол Чойр" ИНС, "Аялал жуулчлалын холбоо" ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Өөдрөг зөвлөл холбоо" ТББ, МҮХАҮТанхимын Говьсүмбэр салбар, "Чойр хөгжлийн шийдэл" ТББ, "Жанжин Чойрын Данжин Сахиус" ТББ-тай санамж бичиг байгуулж, 2021 онд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Төлөвлөгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих өдөр нийт 2000 гаруй мод тарьж, хог хаягдлыг бууруулахад чиглэсэн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн даавуун уутны хэрэглээг хэвшүүлье аян эхлүүлсэн.

Ард Иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад мод, бут тарих боломжийг бүрдүүлэх зорилгоор орон нутагтаа мод үржүүлдэг 3 иргэн, 2 иргэний нөхөрлөлтэй хамтран 21 төрлийн 4600 гаруй мод, бутны худалдаа зохион байгуулсан.

Монгол Улсын Ойн тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу Нэг өрх нэг мод уриан дор 2021 оны 5 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд мод тарих үйл ажиллагааг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 25 аж ахуйн нэгж, байгууллагын 230 гаруй албан хаагч, 350 гаруй иргэн 6871 ширхэг мод бутыг тарьсан.

2021 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Уст цэгийн цэвэрлэгээний ажлыг Байгаль орчин аялал жуулчлалын газар, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын 7 албан хаагч Цоорхой рашаан, Цагаан дарь эх, Чойрын богд уулын орчим, Уулзварын гол тус тус газрын ойр орчим, хогийн савыг цэвэрлэн нийт 2.5 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Хандлагаа өөрчилье багц ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа “Зөв дадал-Эерэг өөрчлөлт, Ногоон ирээдүй” аяны хүрээнд What 3 words буюу 3 үгт хаягжилтын сургалтыг 2021 оны 5 дугаар сарын 14-нд зохион байгууллаа. Тус сургалтад нийт 9 байгууллагын 31 ажилтан албан хаагч хамрагдлаа.

Мэргэжлийн хяналтын газартай хамтран зөвшөөрөлгүй худаг гаргасан 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авхуулж зөрчлийг арилгуулсан.

Тайлант сард азотын давхар исэл (NO<sub>2</sub>) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO<sub>2</sub>) хоногт 2 удаагийн давтамжтайгаар сорьцыг 24 удаа, мөн шинжилгээг 12 удаагийн дээжинд шинжилгээ хийж, дундаж азотын давхар исэл (NO<sub>2</sub>) 0.009 мкг/мг сарын хүлцэх агууламж хэмжээ 0.050 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO<sub>2</sub>) 0.013 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** Байнгын ажиллагаатай станцын хэмжилтийн ажлыг Сүмбэр сумын хот тосгон бусад суурин 5 газарт, Баянтал суманд 1:1000 масштабтай байр зүйн зурагт хяналтын хэмжилтийг 120 цэг дээр хийсэн.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын материалын үйлдвэрлэлийн “Осо констракшн” ХХК, “Илчит Сансар” ХХК-уудын үйл ажиллагаатай танилцан, үзлэг шалгалтыг хийж, материал эдлэлийн үнэ тариф, зөвшөөрлийн гэрчилгээ зэрэгт судалгаа хийлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд Цагдаагийн хэлтсийн барилга угсралтын ажил эхэлж, суурийн ажил хийгдэж байна. Мөн Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 85 хувьтай, Сүмбэр сум 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавих ажил 95 хувьтай тус тус хийгдэж байна. Засгийн газрын нөөц сангийн

хөрөнгөөр хийгдсэн Илчлэг шивээ ОНӨААТҮГ-н зуухны өргөтгөлийн ажилд улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын авто машин, уурын ариутгалын авто машин нийлүүлэх ажлууд хийгдэж, хүлээлгэн өгсөн.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2021 онд нийт 5.275.988,8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс 11 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан байна.

**Орон нутгийн өмчийн талаар:** Орон нутгийн өмчит 43 хуулийн этгээдээс 36 хуулийн этгээд “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-гээ дүгнүүлж, 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дундаж үнэлгээгээр 79.5 хувь буюу хангалттай үзүүлэлттэй байна.

Түрээсийн орлого 25 сая төгрөг төвлөрөхөөс 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар түрээсийн орлого 12.6 сая төгрөг буюу 50 хувьтай төвлөрсөн байна.

### **ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Баянтал сум:** Сумын төвийн багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж, цаг үеийн байдал, хот тохижилт, нийтийн цэвэрлэгээний хуваарь, мод тарилт, арчилгаа, усалгааны талаар хэлэлцүүлээ.

Сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлөөс Хөдөлмөрийн аюулгүй байдлын академитай хамтран 2 удаагийн сургалт зохион байгуулсан.

Ковид-19 өвчлөлийн эсрэг вакцинжуулалтыг өдөр бүр зохион байгуулж байгаа бөгөөд 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 1 дүгээр тунд 900 иргэн хамрагдсаны 273 нь гадны харьяат, 2 дугаар тунд 105 иргэн хамрагдсанаас 13 иргэн нь гадны харьяат бөгөөд нийт 1003 иргэн хамрагдсан байна.

Ковид-19 өвчлөлийн эсрэг вакцинжуулалтанд оролцож буй эмч, сувилагч, бусад албан хаагчдын халдвар хамгааллыг сайжруулах зорилгоор N95 амны хаалт, нэг удаагийн болон даавуун амны хаалт, халдвар хамгааллын хувцас, жавелион зэрэг хэрэгслүүдийг аймгийн Онцгой комиссоос сумын Онцгой комисст олгосныг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

“ӨРХИЙН ТАРИАЛАН АЯН”-ыг “ӨРХ БҮРТ ЭРҮҮЛ ХҮНС” уриатайгаар зарлаж байгууллага, ААНэгж, иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна. Тус аянд 5 байгууллага, 6 иргэн нэгдээд байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2020 онд олгосон хүнсний ногооны үрийн үлдэгдлээс 5 иргэнд 2 кг үр олгосон бөгөөд “Баянтал ногоочид” бүлгэм шинээр үүсгэн ногоочдыг арга зүйгээр хангаж, мэдээлэл сургалтыг 3 удаа зохион байгуулаад байна. Сумын агропаркад 4 иргэн, 2 байгууллага хөрс боловсруулалтын ажлаа дуусгаж, тариалалтаа эхлээд байна.

Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн жижиг төслийн хөтөлбөрийн хүрээнд “Иргэдийн оролцоотой ногоон сумыг бий болгох” төслийг хэрэгжүүлэхээр “Энх Агуулга Сан” ТББ-тай гэрээ байгуулсан. Төслийн хүрээнд 5 дугаар сарын 7-ны өдөр нийт 6 төрлийн 600 ширхэг модны үрсэлгээг хүлээж авч, 40 иргэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд мод тарилтыг 100 хувь гүйцэтгэж дуусган, хамгаалалтын хашаа барих, усалгаа арчилгааг орон нутгийн нөөц боломж, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулж байна.

2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй “4 дүгээр цэцэрлэгийн ширээ, сандал нийлүүлэх” худалдан авах ажиллагааны хүрээнд “Эрхэт рай” ХХК тендерт шалгарч, 15 ширээ, 80 сандал нийлүүлж, тендерийг хүлээн авах комисст хүлээлгэн өгсөн. Үүнээс гадна тус компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд сумын цэцэрлэгт хүүхдийн нойлын хаалт, амны хаалт зэргийг хандивласан байна.

**Шивээговь сум:** Сумын Засаг даргын 2021 оны А/73 дугаар захирамжаар Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг тооллогыг зохион байгуулах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, тооллогыг 2021 оны 5 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 245 авто машин үзлэгт хамрагдсан байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид 2021 оны 5 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд хөдөөгийн малчин 41 өрхөөр тойрч амьдрал ахуйтай нь танилцан иргэдийн санал хүсэлтийг сонсож, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар танилцуулж, Монголын Улаан загалмайн хорооноос 41 өрхөд хүнсний багц олгосон.

Нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууцнуудын орцонд ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилж, нийт 11 орон сууцны 51 орцонд, 4700м<sup>2</sup> талбай,

нийтийн эзэмшлийн 23 цэгийн 72607,5 м2 талбай, нийт 77307,5 м2 талбайг супиркилл /6,2кг/ болон жавельон /102ш/ бодисоор 7,4 тн уусмал зарцуулан хийж гүйцэтгэсэн.

18-аас дээш насны иргэдийг коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулж, сумын хэмжээнд 18-аас дээш насны 2237 иргэн хамрагдахаас 2 дугаар тунд 1143 иргэн, 1 дүгээр тунд 1847 иргэн, нийт 2990 иргэн вакцинжуулалтандаа хамрагдаад байна. Үүнээс түр оршин суугч буюу отроор яваа 386 иргэнийг 1 дүгээр тунд хамруулснаар вакцинжуулалт 97.6 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн яамны санхүүжилтаар "Шүдний кабинет" байгуулан 2021 оны 5-р сарын 21-ний өдөр нээлтээ хийлээ. Нээлтийн үйл ажиллагаанд Монгол улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, сумын удирдлагууд, ШОХК-ийн Гүйцэтгэх захирал, ЭМГ-ын дарга, эмнэлгийн удирдлага, албан хаагчид оролцлоо. Энэ үеэр салбартаа үр бүтээлтэй ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилчдыг төрийн дээд одон медаль болон салбарын шагналуудаар шагнаж урамшууллаа.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэтгэврийн зээлгүй болон 1.0 сая-аас доош зээлтэй байсан иргэдэд "Эрдэнэс бонд"-ын үнэт цаас олгохоор шийдвэрлэсэний дагуу сумын хэмжээнд нийт 147 иргэнд "Эрдэнэс бонд"-ын үнэт цаас ирсэнийг 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн тарааж өнөөдрийн байдлаар зээлгүй байсан 99 иргэнд, 1.0 сая-аас доош зээлтэй байсан 40 иргэнд, нийт 139 иргэнд "Эрдэнэс бонд"-ын үнэт цаасыг олгоод байна.

Энх агуулга төрийн бус байгууллагатай хамтран "Иргэдийн оролцоотой ногоон сумыг байгуулах" төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд хайлаас 200, улиас 100, бургас 65, чацаргана, үхрийн нүд, улаалзгана тус бүр 45 ширхэг ирснийг 33 иргэнд тус бүр хайлаас улиас бургас нийлээд 10 ш, жимсний мод 5, нийт 15 мод олгоод байна.

**Сүмбэр сум:** Халдвараас урьдчилан сэргийлэх, хөрс, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран 3 удаагийн ариутгалын ажлыг зохион байгуулж, 3 дугаар багийн нийтийн эзэмшлийн талбайд 14 цэгийн 48200м2 талбайд ариутгалын ажлыг гүйцэтгэсэн. Ариутгалын ажил 1, 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үргэлжлэн хийнэ.

"Менежмент ба ур чадварын хүрээлэн" төрийн бус байгууллагаас чанарын менежментийн тогтолцоо ISO MNS 9001:2016 стандартыг нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж ажиллалаа.

Аймгийн Байгаль орчин, аялал, жуулчлалын газраас ирсэн ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн "Зуун найман ойл" ХХК-тай 2021 оны ус ашиглах гэрээ байгууллаа.

Отрын айлуудаар Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Аймгийн Хөдөө аж ахуйн газар, хөдөөгийн 5,6-р багийн дарга нар гэсэн ажлын хэсэг байгуулан нийт 77 айл өрхөөр орж зөрчил гаргасан айлуудад хариуцлага тооцон бэлчээр чөлөөлөх албан мэдэгдэл хүргүүлэн ажилласан. Үүний үр дүнд 3 өрх бэлчээр чөлөөлсөн байна.

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР